



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 69

Рашаант

Төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 тоот тушаалын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. 2023 оны санхүүгийн жилд Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулсугай.
2. Хоршоо хөгжүүлэх сангаас өмнө нь авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй, шүүхийн шийдвэр, шүүхийн эвлэрүүлэн зуучлах арга хэмжээнд хамрагдсан Хоршоо, ЖДҮҮЭрхлэгчдэд зээл олгохгүй байхыг Төсөл сонгон шалгаруулах Хорооны дарга (Б.Оюунханд)-д даалгасугай.

ДАРГА



4012100302
ХТҮ0245*9033068

Д.ЖАРГАЛСАЙХАН